



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#7
(28)

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

VII сар

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ
ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН
ОНЦЛОГ
(Нүүр 3-5)**



**СУРГУУЛИЙН НАСНЫ
ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН
ОНЦЛОГ
(Нүүр 7-11)**



**МОНГОЛ ХҮҮХДИЙН ЦОГЦ
ХӨГЖЛИЙН СУДАЛГААНЫ
ДҮГНЭЛТ
(Нүүр 11-13)**



МОНГОЛ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДАР, НИЙГЭМШИЛ, ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ (3-17 НАС)

Монгол Улсын боловсролын салбарын бодлого үйл ажиллагаанд Монгол хүүхдийн хөгжлийн хувийн онцлогийг тооцон тусгаж хэрэгжүүлснээр иргэдийн боловсрол эзэмших үйл явцыг нэмэгдүүлэх шинжлэх ухааны нэг арга зам гэж үзэж 2 шатны судалгааг хэрэгжүүлсэн билээ.

Судалгааны зорилго нь Монголын 3-17 насны хүүхдийн цогц хөгжлийн онцлог тогтоох, нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлснээр боловсролын бодлого, үйл ажиллагаанд тусгах боломжийг бий болгох, цаашилбал үндэсний хэмжээнд бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг судалсан мэдээллийн санг бүрдүүлэх юм.



Тухайн зорилгын хүрээнд нэгдүгээрт, хүүхдийн цогц хөгжлийг нас бүрээр судлах аргачлалуудыг хөгжүүлэх, хоёрдугаарт, үндэсний хэмжээнд төлөөлөхүйц цаашдаа баяжуулах боломжтой мэдээллийн сан бүрдүүлэх, гуравдугаарт, хүүхдийн хөгжлийг чадваруудаар тодорхойлон, түүний өөрчлөлт, нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, дөрөвдүгээрт, 3-17 насны хүүхдийн цогц хөгжлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох ажлуудыг хийж гүйцэтгэсэн юм. Судалгааг бодит хэмжилтийн арга, сэтгэл зүйн сорилыг хэрэглэн явуулсан.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ҮНДЭСЛЭЛ

БСҮХ-ийн судалгааны баг нь БШУЯ-ны захиалгаар, ШУТС-ийн санхүүжилтээр Монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгааг (2014-2017 он), (2019-2022 он) хоёр шаттайгаар хэрэгжүүлсэн.

I шатны судалгаанд сургуулийн өмнөх насны 933 хүүхэд, сургуулийн насны 3164 хүүхэд, II шатны судалгаанд 4019 хүүхэд судалгаанд оролцсон.



Хүний хөгжил нь бие махбод, танин мэдэхүй, нийгэмшилд гарч байгаа эерэг өөрчлөлтийн цогц бөгөөд хүний насан туршид явагддаг гэж үзэх хандлага Барууны орнуудад бий болсоор 30 гаруй жилийн нүүрийг үзжээ (*Baltes, 1987, 2003; Baltes, Lindenberger, & Staudinger, 2006*).

Танин мэдэхүйн хөгжил гэдэг нь мэдээллийг хүртэж хүлээж авах, боловсруулах, учир шалтгаанд нь сэтгэх, шийдвэр гаргах үйл явцыг өөртөө агуулсан оюун ухааны тогтолцоо юм. Энэ нь юмсыг хүртэж хүлээж авах, анхаарлаа төвлөрүүлэх, мэдээллийг тогтоох болон сэтгэхүйн чадварыг өөртөө багтаана.

Бие бялдрын хөгжил гэдэг нь хүний биеийн өсөлт хөгжил, физиологийн үйл явцыг хамардаг ба дотор нь биеийн өсөлт ба бэлтгэлжилт гэж хувааж үздэг.



Нийгэмшлийн чадварыг судлаачид өөртөө хандах хандлага, харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, үнэт зүйлийн төлөвшил, эцэг эх ба хүүхэд хоорондын ээнэгшсэн харилцаагаар авч үзэж байна. Иймээс бид хүүхдийн хөгжлийг бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн эдгээр чадваруудаар судалсан.

Танин мэдэхүй, нийгэмшлийн чадварын үзүүлэлтийг Лайкертийн 5 хэмжээст шкалыг хэрэглэн хөгжлийн 5 түвшинд авч үзсэн. Үүнд: 1-маш сул, 2-сул, 3-дундаж, 4-сайн, 5-маш сайн утгыг илэрхийлнэ.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТ (3-5 нас)


Сургуулийн өмнөх 3-5 насанд хүүхдийн биеийн өндөр хөвгүүдийнх жил бүр ойролцоогоор 5-7 см -ээр өсдөг байна. Охид 6-7 см-ээр өссөн байна. Хөвгүүд охидоосоо илүү өндөр байна. Биеийн өндрийн өсөлтийн эрчимтэй үе нь 5 нас байна.

Зураг 1. Хүүхдийн биеийн өндөр, 3-5 нас (см)



Биеийн жингийн тухайд эрэгтэй хүүхдүүд жилд дунджаар 3-аас 4 нас хүрэхэд 1.4 кг-аар нэмэгддэг бол 4 наснаас 5 нас хүрэхэд 2-3 кг-аар нэмэгддэг, охидын хувьд жил бүр 1.5 - 2 см-ээр нэмэгджээ. Хөвгүүдийн биеийн жин 4-5 насанд харьцангуй нэмэгддэг зүй тогтол харагдлаа.

Зураг 2. Хүүхдийн биеийн жин, 3-5 нас (кг)



СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТ (3-5 нас)

Сургуулийн өмнөх насны боловсролын хөтөлбөрт бие бялдрын бэлтгэлжилтийн чанарыг дараах байдлаар тусгасан байна. Алхах гүйх, Үсрэх харайх, Шидэх дамжуулах барих, Биеийн хөдөлгөөнөө хянах, зохицуулах гэж заасан байна.

Бид хүүхдүүдийн гүйх харайх чадварыг 3 насанд 20 метрийн, 4-5 насанд 30 метрийн зайд гүйлгэж судалсан. Үсрэх харайх чадварыг байрнаас уртад харайх, шидэх дамжуулах чадварыг бөмбөгөөр бай онох аргаар, биеийн хөдөлгөөнөө хянах зохицуулах чадварыг нэг хөл дээрээ тэнцвэрээ олж зогсох аргуудаар судалсан.


Судалгааны үр дүнгээс харахад, нас нэмэгдэх тусам хүүхдүүд зааврыг ойлгож гүйх хурд, тэсвэрт чанар өссөн. Харин хүүхдүүдийн шидэх, барих дамжуулах гэх мэт авхаалж самбаатай чанар сул байлаа.

Зураг 3. Хүүхдийн уян хатан чанар, 3-5 нас (см)



Нэг хөл дээрээ тэнцвэрээ олж зогсох чадвар нас нэмэгдэхэд сайжирсан ба 5 насанд илэрхий нэмэгдсэн. Охидын тэнцвэрт чанар хөвгүүдтэй харьцуулахад статистик ач холбогдлын түвшинд ялгаатай сайн байлаа.

Зураг 4. Хүүхдийн тэнцвэр, 3-5 нас (сек)



Дээрх үр дүнгээс харахад, хүүхдийн биеийн өндөр жин, тэнцвэрт чанар гэх мэт бие бялдрын хөгжил нас нэмэгдэхэд сайжирч байна. Уян хатан чанар харьцангуй нэмэгдэхгүй байна.

ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ (3-5 нас)

Сургуулийн өмнөх насны сургалтын хөтөлбөрт юмсын аль нэг шинж чанараар нь ангилах, ижил төсөөр нь нэгтгэх, дуурайж зурах, будах, янз бүрийн зураас зурах, өгүүлбэр ойлгох, ярих, санаа бодлоо илэрхийлэн ярих чадварыг хөгжүүлэхээр тусгасан байдаг.



Хүүхдүүдийн танин мэдэхүйн чадварыг судалсан үр дүнгээс харахад, хүүхдүүд энгийн юмсыг хараад түүний ялгаатай ба төсөөтэй талыг олж харах сэтгэхүйн чадвар нь 4 насанд сайжирдаг. 5 наснаас янз бүрийн дүрсийг хараад хичээлд үздэг зүйл, гэрийн тавилгуудыг хараад гэрт байдаг юм гэх мэтээр сэтгэхүйн нэгтгэх үйлийг хийх чадвартай болдог байна.

Хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх нь хэвийн дундаж ба 4 наснаас эхэлж хүүхдүүд анхаарлаа зориудаар төвлөрүүлэх үйлдлийг гүйцэтгэх чадвар сайжирдаг байна.




Хүүхдүүд дүрс зургийг таньж, дуурайлгаж цэвэр зурах будах зэрэг үйлдлийг 4 наснаас эхлэн сайн хийх чадвартай болдог ба 5 насанд илэрхий сайжирдаг, 3-4 энгийн өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлдэг байна.

Танил үгийг сонсоод дунджаар 3 настай хүүхдүүд 2-3-ыг, 4 настай хүүхэд 3-4 үг, 5 настай хүүхэд 4 үг тогтоосон байна.



Хүүхдүүд юмсыг хараад зүй тогтлыг нь таньж сэтгэх нь харьцангуй сайн байна. Энэ нь тэдний мэдлэгтэй холбоотой юм. Жишээлбэл, модон дээр байгаа загасыг хараад усанд байх ёстой, буруу зурагдсан, гахай бас модон дээр байгаа нь буруу, тэр газар байх нь зөв гэх мэтээр хэлж байгаа хэрнээ туулайд малгай өмсүүлснийг байж болох мэтээр хүртэж ойлгож байгаа нь тэдний ойлголт төсөөлөлтэй холбоотой юм. Мөн шувуу нохойн үүрний хажууд гинжилснийг 3 настнууд хэлэхгүй байх нь элбэг ч, 4-5 настай хүүхдүүд сайн хэлж байсан. Эндээс харахад, хөтөлбөрт заасан танин мэдэхүйн чадвар хүүхдүүдэд сайн байна.

Зураг 5. Хүүхдийн танин мэдэхүйн чадвар, 3-5 нас (дундаж оноогоор)



ХҮҮХДИЙН НИЙГЭМШЛИЙН ОНЦЛОГ (3-5 нас)

Сургуулийн өмнөх насны сургалтын хөтөлбөрт өөрийгөө мэдрэх, илэрхийлэх, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, бусдыг мэдэрч ойлгох, дүрэм журмыг ойлгож мөрдөх, асуудлыг өөрийн хэмжээнд шийдвэрлэх, насанд хүрэгчдээс шаардлагатай үед тусламж хүсэх, бусадтай хамтран тоглох, ажил үйл гүйцэтгэх чадварыг тусгасан байна.



Хүүхдүүдийн нийгэмшлийн онцлогийг судалсан үр дүнгээс харахад: 3 настайгаас өөрийн нэрийг ихэнх нь бүтэн мэддэг байна. 3 настнуудын ихэнх нь буюу судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 54 хувь нь насаа гүйцэд хэлсэн бол 26 хувь нь хуруугаараа хэлсэн байна. 5 насанд насаа хэлж мэддэг байна.

3-5 настай хүүхдүүдээ нэр, хүйсээ сайн мэддэг болдог байна.




Аав ээжийнхээ бүтэн нэрийг 5 настнууд бүтнээр нь сайн хэлж байсан бол 3 настай хүүхдүүд хагасалж хэлэх нь түгээмэл байдаг байна.

Ам бүлийн тоо болон цэцэрлэгийн бүлгээ мэдэх нь 5 насанд сайжирдаг бол 3-4 настнууд сайн мэдэхгүй байх нь элбэг байна.



Зураг 6. Хүүхдийн өөрийн тухай ойлголт, 3-5 нас (хувиар)




Харилцаа-сэтгэлийн хөдөлгөөний чадварын хувьд, 3 наснаас хүүхдүүд юунд баярлаж гомддоогоо мэдэж илэрхийлж сурдаг байна. Мөн 3 наснаас эхлэн зайлшгүй тохиолдолд хэнээс тусламж дэмжлэг авах талаар ойлголттой болдог байна. Тухайлбал, өвдсөн тохиолдолд ээж, ааваас эмчээс туслалцаа авах талаар мэддэг болдог байна. 3 наснаас хүүхдүүд хогийг хогийн саванд хийх, ногоон гэрлээр гарцаар гарах, олон нийтийн газар ээж аавынхаа зааврыг дагах талаар ойлголттой болж эхэлдэг нь нийгэмшлийн чухал чадвар юм. 3 настай хүүхдүүдийн 59 хувь нь найзтайгаа хамтарч тоглоомоороо хамтдаа тоглох, нийлэмжтэй байх талаар ойлголттой болж эхэлдэг байна. Ганцаараа тоглоомоороо тоглоно, учир нь миний тоглоом тул өгөхгүй гэж хариулж байсан хүүхдүүд нас нэмэгдэх тутам багасаж байгаа нь бусадтай хамтрах чадварт суралцаж байгаагийн илэрхийлэл юм. Хүүхэд ийнхүү бусадтай хамтарч тоглох чадвартай болж байгаа нь тэдний хөгжлийн том үзүүлэлт юм.

Хөдөө орон нутгийн хүүхдүүдийн учир шалтгаанд нь сэтгэх, юмсын ижил төстэй ба ялгаатай талыг харьцуулан ойлгох сэтгэхүйн чадвар, анхаарлаа төвлөрүүлэх, богино хугацаанд мэдээллийг харж тогтоох чадвар нь нийслэлийн хүүхдүүдтэй харьцуулахад сайн байна ($p < 0.01$)

БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТ (6-17 нас)


Насны нэг үе шатаас нөгөө үе шатанд шилжихэд эрэгтэй хүүхдүүдийн цээжний тойрог ойролцоогоор 10- аад см -ээр, бүсэлхийн тойрог 6-7 см-ээр нэмэгддэг бол эмэгтэй хүүхдүүдийн цээжний тойрог 11-14 насанд хүрэхэд 11-12 см-ээр, харин 15-17 насны үед 6-7 см-ээр нэмэгдэж бүсэлхийн тойрог нь 15-17 насанд л ойролцоогоор 3 см-ээр нэмэгддэг зүй тогтол харагдлаа ($p < 0.01$).

Зураг 7. Хүүхдийн биеийн өндөр, 6-17 нас (см)



Таван жилийн өмнөх буюу эхний судалгааны үр дүнтэй харьцуулахад хүүхдийн биеийн өсөлт нэмэгдсэн байна ($p < 0.01$).

Зураг 8. Хүүхдийн биеийн жин, 6-17 нас (кг)



Хүүхдүүдийн хурдны чанар 11-14 насанд бага зэрэг буурч, 15-17 насанд буцаад өссөн байна (Богино зайг хурдтай туулах чадвар – 50 м). Мөн нас нэмэгдэх тусам хүүхдүүдийн холын зайг тэсвэртэйгээр туулах чадвар буурч байна.

Эрэгтэй хүүхдүүдийн хүчний чанар нас нэмэгдэхэд тогтвортойгоор нэмэгдэж байгаа бол охидынх өсөхгүй байна.

Эрэгтэй хүүхдүүдийн уян хатан чанар 15-17 насанд мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа бол эмэгтэй хүүхдүүдийнх нас нэмэгдэх тусам тогтвортойгоор сайжирсан дүр зурагтай байна.

Хөдөө орон нутгийн хүүхдүүдийн уян хатан чанар, хүч Улаанбаатар хотын хүүхдүүдтэй харьцуулахад сайн бол Улаанбаатар хотын хүүхдүүд холын зайг тэсвэртэйгээр туулах чадвар илүү сайтай байна ($p < 0.01$)

Таван жилийн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад, хүүхдүүдийн богино зайг хурдтайгаар туулах чадвар болон биеийн уян хатан чанар буурч хүчний чанар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮҮХДИЙН ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖИЛ (6-17 нас)

Мэдээллийг хүртэж хүлээх чадварыг хүртэхүй, анхаарлын төвлөрөл, богино хугацаанд мэдээллийг харж тогтоох болон сонсож тогтоох чадвараар судаллаа.


Фактор анализын шинжилгээгээр мэдээллийг хүртэж хүлээж авах чадварыг илэрхийлэх хувьсагч хоорондоо холбоо хамааралтай ба найдвартай байдлын үзүүлэлт нь 0.6 -аас их байв.

Мэдээллийг хүртэж хүлээж авах чадварт хамгийн чухал нь богино хугацаанд мэдээллийг харж тогтоох ялангуяа, цифр, тоо гэх мэт нарийн мэдээллийг харж тогтоох ойн чадвар болон анхаарлаа төвлөрүүлэх чадвар чухал байр суурьтай байлаа. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Мэдээллийг хүртэж хүлээж авах чадварын статистик шинжилгээ

Фактор	Фактор утга	Кронбахь альфа утга
Хүртэхүйн чадвар	.485	
Анхаарлаа төвлөрүүлэх чадвар	.726	
Богино хугацаанд дүрс-мэдээллийг харж тогтоох чадвар	.716	.658
Богино хугацаанд цифр-мэдээллийг харж тогтоох чадвар	.780	
Богино хугацаанд мэдээллийг сонсож тогтоох чадвар	.493	

Зураг 9. Мэдээллийг хүртэж хүлээж авах чадваруудын дундаж үзүүлэлт



6-10 нас

Хүүхдүүдийн хувьд юмсыг ерөнхийд нь хурдан хүртдэг ба бүтэц бүрэлдэхүүнд нь хүртэхдээ бэрхшээдэг, анхаарлаа төвлөрүүлэн хурдтай оновчтой ажиллах, цифр тоо гэх мэт мэдээллийг богино хугацаанд харж тогтоох нь сул ба анхаарлаа зориудаар төвлөрүүлэн ажиллахдаа хялбар ядардаг талтай.

Хүүхдүүд мэдээллийг богино хугацаанд ажиглан бүтэц бүрэлдэхүүнд нь хүртэх чадвар харьцангуй сайн, богино хугацаанд дүрс хэлбэрийн мэдээллийг харж оновчтой тогтоох нь сайн бол цифр тоо зэрэг мэдээллийг богино хугацаанд харж тогтоох нь өмнөх насны үетэй адил сул байна. Анхаарлаа зориудаар төвлөрүүлэн хурдтай оновчтой ажиллах нь 6-10 настай харьцуулахад сайжирдаг, гэхдээ ачааллыг нь зайлшгүй тооцож үзэхгүй бол хялбар ядарч бүтээмж буурах хандлагатай.

11-14 нас

15-17 нас

15-17 насанд хүүхдүүд анхаарлаа төвлөрүүлэн хурдтай бүтээлч ажиллах чадвар сайжирдаг тул ачааллыг даах нь сайн байна. Богино хугацаанд цифр тоо гэх мэт мэдээллийг харж тогтоох чадвар болон мэдээллийг бүтэц бүрэлдэхүүнд нь ажиглан хүртэх чадварыг нь сургалт хөгжлийн үйл ажиллагаагаар дэмжих үйлийг хийх нь юмс үзэгдэл, үйл явдалд нухацтай, өнгөц бус хүртэж хүлээж авах чадварыг нь нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Хүүхдүүдийн мэдээллийг хүртэж хүлээж авах чадварт газар зүйн байршил статистик ач холбогдолтой түвшинд нөлөөлсөн бөгөөд хотын хүүхдүүд орон нутгийн хүүхэдтэй харьцуулахад богино хугацаанд мэдээллийг тогтоох чадвар нь харьцангуй сайн байна. Хөдөө орон нутгийн 6-10 настай хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллах нь хотын хүүхдүүдтэй харьцуулахад сайн байна ($p < 0.01$)

Таван жилийн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад, богино хугацаанд мэдээллийг тогтоох чадвар сайжирсан, анхаарлын төвлөрөл буурсан байна ($p < 0.01$).

ХЭЛ ЯРИАНЫ СЭТГЭХҮЙН ХАРЬЦУУЛАХ АНГИЛАХ ЧАДВАР (6-17 нас)


Хэл ярианы сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадварыг утгаар нь мэдээллийг тогтоох, үгийн утгыг тайлбарлах, үгийг харьцуулан нэгтгэн дүгнэх даалгавраар судалсан.

Фактор анализын шинжилгээгээр хэл ярианы сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадварыг илэрхийлэх хувьсагчдын хооронд өндөр холбоо харилцан хамааралтай, мөн найдвартай чанарын үзүүлэлт нь хангалттай байна. Үгийн утга тайлбарлах, түүн дотор хийсвэр утгатай үгийг тайлбарлах чадвар нь хэл ярианы сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадварын түвшинд гол байр суур эзэлдэг нь факторын шинжилгээгээр харагдлаа. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Хэл ярианы сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадварын статистик үзүүлэлт

Фактор	Фактор утга	Кронбахь альфа утга
Мэдээллийг утгаар нь тогтоох чадвар	.567	
Бодит утгатай үг тайлбарлах чадвар	.727	
Хийсвэр утгатай үг тайлбарлах чадвар	.771	.760
Салаа утгатай үг тайлбарлах чадвар	.711	
Хэл ярианы сэтгэхүйн харьцуулан нэгтгэн дүгнэх чадвар	.697	
Математик сэтгэхүйн чадвар	.603	

Зураг 10. Хэл ярианы ерөнхийлөн дүгнэх чадварын дундаж үзүүлэлт, насны бүлгээр



Сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвар буюу юмс үзэгдлийн гол шинжийг нь хийсвэрлэн таньж нэгтгэн дүгнэж ойлгох чадвар нас нэмэгдэх тусам сайжирдаг зүй тогтол судалгаагаар ажиглагдлаа ($p < 0.01$).

Сургуулийн насанд тухайн чадварыг сайжруулах нэг арга нь үг, нэр томъёог тайлбарлах үйлийг хийх нь үр дүнтэй байна. Үг хэллэг, нэр томъёоны талаарх ойлголтыг сайтар ойлгох үйл хийсвэр сэтгэхүйн хөгжлийн хөшүүрэг гэж харагдахуйц байна.

Улаанбаатар хотын хүүхдүүдийн хэл ярианы сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвар хөдөө орон нутгийн хүүхдүүдээс харьцангуй сайн байна ($p < 0.01$)

Таван жилийн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад үгийн утга тайлбарлах логик чадвар буурсан.

Ярих чадварын хувьд энгийн богино өгүүлбэрээр ярьдаг, нийлмэл ялангуяа, холбоос бүхий хавсарсан нийлмэл өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлдэггүй байна.

Бага ангид юмсыг харагдаж байгаагаар нь тоочин ярих хандлагатай бол нас нэмэгдэх тусам ерөнхийлөн дүгнэж ярих нь нэмэгдэж байна. Дунджаар 2 минутад сана бодлоо зориудаар илэрхийлэхдээ 6-10 насанд дунджаар 35 үгээр ярьж байгаа бол 11-14 насанд 32 үг хэрэглэжээ.


ХҮҮХДИЙН НИЙГЭМШЛИЙН ЧАДВАРЫГ СУДАЛСАН ҮР ДҮН

Фактор анализийн шинжилгээгээр нийгэмшлийн чадварыг илэрхийлэх хувьсагч хоорондоо холбоо хамааралтай ба найдвартай байдлын үзүүлэлт нь 0.81 байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Нийгэмшлийн чадварын статистик үзүүлэлт

Фактор	Фактор утга	Кронбахь альфа утга
Өөртөө хандах хандлага	.549	.814
Сэтгэлийн хөдөлгөөний чадвар	.717	
Дасан зохицох чадвар	.794	
Эцэг, эх ба хүүхэд хоорондын ээнэгшилт	.782	
Харилцааны чадвар	.820	
Үнэт зүйлийг баримтлах чадвар	.401	

Зураг 11. Нийгэмшлийн чадваруудын дундаж үзүүлэлт, насны бүлгээр



Нийгэмшлийн чадварын хувьд, 6-10 насанд хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, бусадтай харилцах хамтрах идэвх сонирхол, бусдын сэтгэл санааг ойлгож харилцах, өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, эцэг эхтэйгээ дотно харилцах чадвар сайн байлаа.

11-14 насанд хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, бусдын сэтгэл санааг ойлгож харилцах, бусдыг хүлээн зөвшөөрөх, өөрийн зан төлөвөө ухамсартайгаар удирдан зохицуулах эцэг эхтэйгээ харилцах нь тодорхой хэмжээнд буурдаг байна.

Нийгэмшлийн чадварын хувьд, 6-10 насанд хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, бусадтай харилцах хамтрах идэвх сонирхол, бусдын сэтгэл санааг ойлгож харилцах, өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, эцэг эхтэйгээ дотно харилцах чадвар сайн байлаа.



Хөдөө орон нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад Улаанбаатар хотын хүүхдүүдийн хувьд:

- 6-10 насанд дасан зохицох чадвар,
- 6-10 нас болон 11-17 насанд харилцааны чадвар, эцэг эх хүүхэд хоорондын харилцаа,
- 15-17 насанд сэтгэлийн хөдөлгөөний чадвар буюу өөрийн сэтгэлийн хөдөлгөөний ойлгох, бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар сайн байна ($p < 0.01$).

Харин 6-10 насанд хөдөө орон нутгийн хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний чадвар сайн байна. ($p < 0.01$)

Таван жилийн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, бусдын сэтгэл санааг ойлгож харилцах, эцэг эхтэйгээ дотно харилцах, сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, үнэт зүйлийн төлөвшлийн хувьд эрүүл аюулгүй орчинд амьдрах, амжилтыг чухалчлах нь нэмэгдсэн бол олон талт шударга харилцаа чухал гэж үзэх нь буурсан дүр зураг харагдлаа ($p < 0.01$) (Н.Бэгз, С.Санжаабадам, Б.Энхбаяр нар, 2023)

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ- СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХЭД

Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжихдээ



Хүүхдүүдийн оновчтой шидэх дамжуулах чадварыг нь сургалт хөгжлийн олон талт үйл ажиллагаагаар дэмжих нь зүйтэй байна.

Хүүхдүүдийн уян хатан чанарыг дэмжихийн тулд дасгал хөдөлгөөн хийх, бүжгийн аянд хөдлөх төрөл бүрийн дасгалыг хийхэд хүүхэд бүрийг тэгш хамруулах, цаашилбал, уян хатан чанарыг хөгжүүлэх талаар эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөн туслах ажлыг хийх нь үр дүнтэй юм.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийг дэмжихдээ



Зурах, бичих, тоо тоолох, бусад бүтээх үйлд хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх үйлдлийг тогтмол хийлгэх. Ялангуяа, 4 наснаас хүүхэд зурах, будах, бичих гэх мэт үйлдлийг хийж чаддаг болоход анхаарах нь чухал байна.

Дүрс зургийг дуурайлгаж зурах, зурааснаас гарахгүй будах, ялангуяа 4 наснаас янз бүрийн дүрс зургийг нэмэх хасах гэх мэт нарийн тэмдэглэгээ харж дуурайж тэмдэглэх, тоо бичих, үсэг бичих гэх мэт үйлдлийг хурдан хугацаанд хийх;

Юмсыг хэлбэр, хэмжээ эсвэл төрөл зүйлээр нь ангилан нэгтгэж нэг бүлэг болгон ерөнхийд нь нэрлүүлэх үйлдлийг хийх;



Байгаль нийгмийн энгийн юмс үзэгдлийн тухай ойлголт төсөөлөл эзэмшихэд нь дэмжих; (жишээлбэл, хүн нисэх боломжгүй, шүхэр бариад өндрөөс үсрэх нь зохиомол зүйл, амьтан ярих боломжгүй талаарх ойлголт өгөх нь юмсын учир шалтгааны сэтгэхүй хөгжихөд дэмжлэг үзүүлнэ)



Хүүхэдтэй ярилцах, асуулт асуух, асуултад нь хариулах, өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэхийг дэмжих, үлгэр, үзсэн зүйлийг нь яриулах

Сургуулийн өмнөх насны хүүхдийн нийгэмшлийн чадварыг дэмжихийн тухайд:



Өөрийн нас, нэр, хүйс, аав ээжийнхээ нэр, гэр бүлийнхээ гишүүдийн нэр, нас, хүйс, цэцэрлэгийн бүлгийг илэрхийлэх чадвартай болгох; хүүхэдтэй харилцан ярилцдаг байх



Өөрийнх нь болон бусдын сэтгэлийн хөдөлгөөний илрэлийн талаар ярилцах, өөрт нь юу таалагддаг, юу тааламжгүй санагддаг, ямар үед баярладаг, ямар үед уур нь хүрдэг, тухайн үедээ ямар үйлдлээр илэрхийлдэг, ээж аав нь баярласан, гомдсоныг хэрхэн мэддэг гэх мэтээр ярилцах;



Мөн сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг дуурайлгах; зураг харуулж яриулах; хүүхэдтэй харилцахдаа сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг нүүр царай, дохио зангаагаар тод илэрхийлдэг байх гэх мэт



Бусадтай хамт тоглох, хамтдаа бүтээх, бусадтай өөрийн зүйлээ хуваалцах чадварыг дэмжих



Хүндлэх мэндлэх зан үйлийг эзэмшүүлэх



Хүүхэд хэзээ хэрхэн бусдаас дэмжлэг тусламж авах талаар ойлголт өгөх; Айдаст оруулсан ойлголт өгөхөөс зайлсхийх (жишээлбэл, эмчид хэлж тариулна, багшид нь хэлж загнуулна гэх мэт)



Хэм хэмжээг дагах талаар насанд хүрэгчид гэр бүл, олон нийтийн газар өөрсдөө үлгэр дуурайл үзүүлэх, тайлбарлаж ойлгуулах нь нийгэмшлийн чадварыг дэмжихэд чухал юм.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ- СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХЭД

Сургуулийн насны хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжихдээ



ЕБС-ийн насны хүүхдүүдийн холын зайг тэсвэртэйгээр туулах болон богино зайг хурдтайгаар туулах чадвар, уян хатан чанарыг хөгжүүлэхэд хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг чиглүүлэх, гэр бүлийн орчинд дасгал хөдөлгөөнийг амьдралын хэв маяг болгох тал дээр зөвлөн туслах ажлыг хийх, гарч байгаа өөрчлөлтийг холбогдох мэргэжлийн хүмүүс явцын үнэлгээ хийх, сайжруулах үйл ажиллагааг тогтмолжуулах нь үр дүнтэй байж магадгүй байна.



Охидын хүчний чанарыг тасралтгүй нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.



Сургуулийн насны хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийг дэмжихдээ



Бага ангийн хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх, юмсыг бүтэц бүрэлдэхүүнд нь ажиглах, богино хугацаанд мэдээллийг хүртэж ойлгох чадварыг нь тодорхой арга зүйгээр дэмжих, тухайн чадварыг нь сургалт хөгжлийн үйл ажиллагаандаа харгалзан үзэж ачааллыг нь зохицуулах хэрэгтэй байна.



Хүүхдүүдийн сэтгэхүй хэл ярианы чадварыг бага ангид үгийн утгыг сайтар ойлгоход нь дэмжсэн үйлийг хийх, хийсвэр, салаа/ижил утгатай үгийг сургалт хөгжлийн явцад онцлогийг нь харгалзахгүй хэрэглэх нь үр дүнгүй байдлыг бий болгох тул бодитоор тайлбарлах, тэдний ойлгох түвшний бодит утгатай үгийг хэрэглэх нь зохимжтой юм. Дунд ангид сургалтын агуулга арга зүйгээр тэмдэг нэр, салаа/ижил утгатай үгийн нөөцийг нэмэгдүүлэх үйлийг хийх нь үр дүнтэй нь харагдлаа.



Хүүхдүүдийн утгаар нь мэдээллийг тогтоох нь хэвийн дундаж түвшинд байгаа тул түүнийг төрөл бүрийн үйл ажиллагаагаар зорилготой дэмжих нь зайлшгүй чухал байна. Үзэгдэл юмсын гол нийтлэг шинж, мөн чанарыг нь таньж нэгтгэн дүгнэх, шийдвэрлэх чадварыг нь сайжруулах, ялангуяа үгийн утга, нэр томъёог оновчтой тайлбарлах чадварыг дэмжих хэрэгцээтэй байна. Тэрчлэн хүүхдүүд анхаарлаа төвлөрүүлэн хэд хэдэн үйлдэл бүхий бодлого даалгаврыг янз бүрийн аргаар шийдвэрлэдэг чадварыг төлөвшүүлэх нь хөгжлийг дэмжихэд үр дүнтэй байхуйц дүр зураг харагдлаа.



Сургуулийн насны хүүхдийн нийгэмшлийн чадварыг дэмжихийн тухайд



Бага ангид хүүхдүүд өөрийн талаарх ойлголт нь эерэг, өөртөө итгэх итгэлтэй, бусадтай харилцах хамтрах сонирхол, нээлттэй сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг нь харгалзан тэднийг урамшуулан сэдэлжүүлэх, сургалт хөгжлийн үйл ажиллагаанд жигд оролцуулах, нээлттэй илэн далангүй харилцах нь харилцаа, сэтгэлийн хөдөлгөөний хөгжилд чухал юм.

Сургуулийн дунд, ахлах ангид хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, бусдын сэтгэл санааг ойлгож харилцах эмпати чадвар, ээж аавтайгаа нээлттэй харилцах чадварыг дэмжихэд сургалт хөгжлийн үйл ажиллагааг чиглүүлэх нь чухал байна

Хот ба хөдөө орон нутгийн ялгаатай байдлын хувьд, хөдөө орон нутгийн хүүхдүүдийн холын зайг тэсвэртэйгээр туулах, анхаарлын төвлөрөл, хийсвэр сэтгэхүйн хөгжил, бусадтай харилцах, эцэг эхтэйгээ нээлттэй харилцах, бусдыг хүлээн зөвшөөрөх дасан зохицох, 15-17 насанд нь сэтгэлийн хөдөлгөөний чадварыг дэмжих нь зүйтэй байна ($p < 0.01$).

Улаанбаатар хотын хүүхдүүдийн тухайд биеийн уян хатан, хүчний чанар, анхаарлын төвлөрлийг сургалт хөгжлийн үйл ажиллагаагаар дэмжих үйлийг сургууль гэр бүлийн хүрээнд дэмжих нь хөгжлийг дэмжих нэг тал болж байна ($p < 0.01$).

Ойролцоогоор 5-6 жилийн дараа хүүхдүүдийн биеийн өсөлт, биеийн хүчний чанар, мэдээллийг харж механикаар тогтоох, сэтгэхүйн харьцуулах чадвар, өөртөө итгэх итгэл, харилцаа, сэтгэлийн хөдөлгөөний чадвар, аюулгүй орчин, амжилттай байдлыг эрхэмлэх нь нэмэгдсэн бол биеийн уян хатан, хурдны чанар, анхаарлын төвлөрөл, сэтгэхүйн ерөнхийлөн нэгтгэн дүгнэх чадвар, олон талт шударга харилцааг эрхэмлэх зэрэг нь буурсан дүр зурагтай байгааг бид сургалт хөгжлийн үйл ажиллагаагаар тасралтгүй сайжруулах зорилтыг төлөвлөн хэрэгжүүлбэл үр дүнтэй байх нь харагдлаа ($p < 0.01$).